



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/205

Мандалговь

Залуу багш нарын ур чадварын
уралдаан зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний, удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.6, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 19 дугаар тогтоол, сумын засаг даргын А/92 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багшийн хөгжлийг дэмжсэн Шилдэг сургууль шалгаруулах журмын хүрээнд сумын ерөнхий боловсролын сургуулиудын 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа залуу багш нарын дунд ур чадварын уралдааныг 2020 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулж, шалгаруулж шалгуур үзүүлэлтээр үнэлэхийг ажлын хэсэг (Б.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 700000 (Долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), ня-бо (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ